

ТЭРГҮҮН ӨГҮҮЛЭЛ

**ДОРНО ДАХИНЫ УЛС ТҮМНИЙ ҮНДЭСНИЙ ЭРХ
ЧӨЛӨӨНИЙ ТЭМЦЛИЙН ӨРНӨЛТ ДЭХ КОМИНТЕРНИЙ
VII ИХ ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН АЧ ХОЛБОГДОЛ,
ОРЧИН ҮЕ****Э. Пунцаг**

1929—1933 оны дэлхийн эдийн засгийн хямрал капиталист ертөнцийн бүх зөрчлийг хурцатгаж фашист Итали 1935 онд Абиссини (Этиоп) руу, Итали, Герман 1936 онд Испанийн Бүгд Найрамдах Улс руу довтолж тэдгээр довтолгооч орнуудад фашист дэглэм тогтсоноор Европт дэлхийн шинэ дайны голомт үүсч байв. 1936 онд Германтай «Коминтерний эсрэг гэрээ» байгуулж холбоотон нь болсон империалист Япон Алс Дорнодод дайн зарлалгүйгээр Манжуурыг 1931 онд, Өвөр Монголын хагасыг 1933 онд тус тус бараг эсэргүүцэлгүй эзлээд улмаар ЗХУ, БНМАУ-ын эсрэг зэвсэгт өдөөн хатгалга үйлдэж байсан нь Алс Дорнод дахь дайны бас нэг голомт болов. Үүний дохио нь Японы империалистуудын өдөөсөн 1938 оны Хасан нуруу, 1939 оны Халхын голын байлдаан байлаа. Ийнхүү дэлхийн олон улсын харилцааны байдал ноцтой хурцадсан 30-аад оны дундуур Коминтерн Өрнө дахины хөгжингүй орнуудад фашизмын эсрэг нэгдсэн фронт дорно дахины колони ба хараат орнуудад империализмын эсрэг нэгдсэн фронт, байгуулах тактикийг хэрэгжүүлэх алхамд шилжсэн билээ. Энэ үйл хэрэгт Коминтерний VII их хурал чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Коминтерний VII их хурал Москвад 1935 оны 7-р сарын 25-наас 8-р сарын 25 хүртэл хуралдлаа. Дайн, фашизмтай тэмцэх уриан дор болсон түүхт энэ их хурал коммунист 65 намын 510 төлөөлөгч (таслах эрхтэй 371 оролцжээ.)

«Фашизм бол санхүүгийн капиталын хамгийн харгис, хамгийн үндсэрхэх дээрэнгүй, хамгийн эзэрхэг түрэмгий элементүүдийн илэн далангүй алан хядагч диктатур» гэсэн Коминтерний Гүйцэтгэх хорооны 1933 оны заалтыг Коминтерний VII их хурал албан ёсоор сайшаасан энэ тодорхойлолт нь өнөө хүртэл фашизмын гол тодорхойлолт болсон хэвээр байна. Фашизм ба дайныг эсэргүүцэх ард түмний тэмцлийн үндэс нь ардын фронтын хөдөлгөөн болох ёстой гэж их хурал үзээд фашизмыг эсэргүүцэх ардын нэгдсэн фронт байгуулахад баримтлах коммунист намуудын улс төрийн бодлогыг боловсруулан тавьжээ. Их хурлын тогтоолд ажилчин ангийн нэгдсэн фронт нь Ардын фронтын цөм нь болох ёстойг заахын зэрэгцээ тодорхой

нөхцөлд Ардын фронтын засгийн газар байгуулах бололцоотойг их хурлын гол илтгэгч Г. Димитров цохон тэмдэглэж байв. Ийм нэгдсэн фронтын засгийн газар бүхий ардын ардчилсан улсууд дэлхийн II дайны дараа байгуулсан билээ. Их хурлын өөр нэг тогтоолд фашист цэргийн эвслийг эсэргүүцэх дэлхий дахины энх тайвны өргөн фронт байгуулах тухай ЗХУ-ын чармайлтыг дэмжиж дайн, фашизмыг эсэргүүцэх тэмцлийн нэгдмэл фронтыг олон улсын хэмжээнд байгуулахын чухлыг заажээ. Өөрөөр хэлбэл фашистын түрэмгийлэлд хамтын хүчээр няцаалт өгөхийг ЗХУ одоогоос хагас зуун жилийн өмнө дэлхий дахинд уриалж байсан бол өнөө үед империализмын эсрэг мөн хамтын хүчээр тэмцэхийг уриалж байна. Коминтерний VII их хурал дэлхий дахинд хурдан нэмэгдэж байгаа зэвсгээр хөөцөлдөх явдлыг хязгаарлан устгах тухай асуудлыг бас хөндөн тавьж байжээ.

Коминтерний VII их хурал ийнхүү тухайн үедээ өнөө үеийнх шиг олон улсын тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавьсныг өрнөдийн гүрнүүд хүлээн авч хэрэгжүүлсэн бол дэлхийн II дайныг сэрэмжлэн зайлуулах боломжтой байсныг үгүйсгэх аргагүй. Дайны аюулын тухай их хурлын тогтоол (илтгэгч нь П. Толъятти)-д олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний онол, практикийн чухал асуудлыг дэвшүүлсэн юм. Түүнд дайныг сэрэмжлэн зайлуулах тухай Лениний заалт болон дайн нэгэнт эхэлбэл түүнийг аль болох хурдан дуусгах, дайнаар буй болсон эдийн засгийн, улс төрийн хямралыг хөрөнгөтөн ангийн ноёрхлыг түлхэн унгаах явдлыг хурдасгахад ашиглахыг коммунистуудын үүрэг гэж Ленин, Люксембург нарын томьёолж II интернационалын Штутгартын их хурал (1907он)-ын шийдвэрт тусгагдсан алдарт заалтыг иш үндэс болгожээ.

Дайн фашизмыг эсэргүүцэх тухай Коминтерний VII их хурлаас тунхагласан түүхэн шийдвэр нь АНУ, түүний хамсаатны зэвсгээр хөөцөлдөх дайнч түрэмгий бодлогын уршгаар олон улсын харилцаа хэзээ хэзээнээс илүү хурцадсан өнөө үед ч чухал ач холбогдолтой хэвээр байна.

Коминтерний VII их хурал дайн, фашизмыг эсэргүүцэхийг анхааруулаад зогсоогүй, уг тэмцлийн зохион байгуулалт, арга хэлбэрийг марксизм-ленинзм, олон улсын коммунист хөдөлгөөний онол практиктай хослуулан судалж тодорхой улс районд коммунист намын баримтлах улс төрийн бодлогыг боловсруулж өгчээ. Олон улсын коммунист хөдөлгөөн, үндэсний чөлөөлөх тэмцлийн түүхэнд Коминтерний VII их хурлын оруулсан нэг чухал хувь нэмэр үүнд оршино.

Өнөөдөр дэлхийн янз бүрийн бүс нутагт неофашист дээрэмчдийн алан хядах ажиллагаа явагдсаар байгаагийн зэрэгцээ арьс өнгөөр гадуурхах үзэл амь бөхтэй зууралдаж, хонзоглогчид бусдын дэвсгэр нутагт санаархсаар байгаа нь фашизмыг дахин сэргээх аюултай болгож байна. Фашизм нь дайн үүсгэдгийг түүх нэгэнт харуулсан билээ.

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачевын хэлснээр «Хүн төрөлхтөнд өнөөгийнх шиг ийм аймшигтай занал хэзээ ч тулгарч байгаагүй. Бий болсон энэ байдлаас гарах цорын ганц ухаалаг зам бол сөрөн зогсож буй хүчнүүд эх дэлхий дээрээ зэвсгээр хөөцөлдөхийг сансарт дэлгэрүүлэхгүй байх талаар тохиролцох явдал болно»²

Олон улсын харилцааны ийм хурцадмал нөхцөлд фашизмыг ялсны их ойг цөмийн зэвсгийн аюул заналыг ялгах уриан дор тэмдэглэж

2. М. С. Горбачев. 1985 оны 3-р сарын 11-нд ЗХУКН-ын ТХ-ны бүгд хурал дээр хэлсэн үг, «Үнэн» 1985. 3. 13.

империализм, дайныг эсэргүүцсэн олон улсын өргөн фронт байгуулах явдлыг өнөөгийн олон улсын амьдрал өөрөө дэвшүүлэн тавьж байна.

1930-аад оны дундуур дайн, фашизмыг эсэргүүцэхтэй уялдан гарч, ээлжнээ тавигдсан хойшлуулшгүй нэг чухал зорилт бол ардын нэгдсэн фронт байсан түүхтэй. Ардын нэгдсэн фронт нь Коминтерний VII их хурлын анхаарлын төвд байсан гол зангилаа асуудал юм. Их хурлын тогтоолд «Колони ба хагас колони орнуудад коммунистуудын чухал зорилт нь империализмыг эсэргүүцэх ардын фронт байгуулах ажил»³ гэж заасан нь дарлагдсан ард түмэн, ялангуяа Японы империалистуудын түрэмгийллийн бай болсон Хятадын хувьд онц чухал ач холбогдолтой нь мэдээж байв. Гэвч Коминтерний энэ чухал заалт биелэгдэтлээ багагүй саад бэрхшээл гэтлэн давж цөөнгүй цаг хугацааг туулсан билээ. Дорнодахины орнууд дотроо хамгийн том бөгөөд нөлөөтөйд тооцогдож байсан ХКН-ын дотор ч нэгдсэн фронтын талаар нэгдмэл санал байж чадсангүй. ХКН-ын ТХ-ны дотор иргэний дайныг үргэлжлүүлэх гэсэн Мао тэргүүтэй томоохон хэсэг, Японыг эсэргүүцэх үндэсний нэгдэн фронт байгуулах гэсэн Коминтерний Ван Мин тэргүүтэй багаахан хэсгийн хооронд зарчмын ялгаатай хоёр чиглэл гарч байв. Нэгдүгээр хэсгийн баримталж байсан чиглэл нь Японы түрэмгийлэгчдийн эсрэг үндэсний чөлөөлөх тэмцлийг өрнүүлэхэд биш, харин дотооддоо Гоминданы эсрэг тэмцэх иргэний дайн, гадаадад ЗХУ-ыг гоминданы Хятад Япон хоёрын аль нэгэнтэй буюу хоёулантай нь зэрэг мөргөлдүүлэх бодолтой байв. Энэ чиглэл нь фашизмын эсрэг, дайны эсрэг тэмцэх гол агуулга нь болсон Коминтерний VII их хурлын уур амьсгал, шийдвэрт харшилж, Японы эсэргүүцэх нэгдсэн фронт байгуулж, улс орноо чөлөөлөн, дайныг түргэн дуусгах гэсэн Хятадын хөдөлмөрчдийн хүсэл эрмэлзэлд нийцэхгүй байв.

Энэ үед Хятадын нийгэм—улс төрийн амьдралд ноцтой өөрчлөлт гарах хүчин зүйлүүд гарч ирлээ. Япон тэргүүтэй гадаадын капиталын өрсөлдөх нөлөөнд жижиг, дунд хөрөнгөтнүүд цохигдох болсон учир тэр нутаг орон, үйлдвэр аж ахуйгаа Японд эзлүүлж буулт хийсэн Гоминданы бодлогод дургүйцэж эхэллээ. Энэ нь Хятадын ард түмний үндсээ аврах тэмцлийг ХКН толгойлж, улмаар империализмыг эсэргүүцсэн нэгдсэн фронтын тактикийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцлийг бүрэлдүүлж байв. Харин империализмыг эсэргүүцэх үндэсний нэгдсэн фронт байгуулах зорилтыг Зөвлөлт засгийн төлөө тэмцэлтэй буюу өөрөөр хэлбэл Чан Кайши тэргүүтэй Гоминданы урвагч бүлэгтэй хийх тэмцэлтэй давхцуулж болохгүйг Хятадын улс төрийн амьдралын тухай байдал шаарджээ. Гэтэл Мао болон түүний талыг баримтлагч «зүүний» сектант бүлэг үндэсний нэгдсэн фронтын бодлогод ондоо хандлагатай байсан юм. Тийм хандлага нь Коминтерний VII их хурлын өмнө болон хурлаас хойш ч тэдний баримталсаар байсан Японыг эсэргүүцэх хувьсгалт дайныг Чан Кайшийг эсэргүүцэх иргэний дайнтай давхцуулж дайныг гадаадын империализм, дотоодын эсэргүү хүчний эсрэг «Хоёр фронт» дээр явуулах гэсэн бодлогоор нотлогдож байв. Мао ийм бодлогоо үргэлж хамгаалсаар ирсэн нь түүний 1956 онд хэлсэн үгнээс ч илт байна.⁴

Коминтерний Гүйцэтгэх хорооны дэргэдэх Ван Мин тэргүүтэй ХКН-ын төлөөлөгчдийн газар намынхаа нэрний өмнөөс 1935 оны 8-р сарын 1-нд гаргасан тунхаглал, мөн оны 11-р сарын 25-нд Хятадын ард түмэн, зэвсэгт хүчинд хандаж гаргасан хоёр уриалгад фашизм,

3. Уильям З. Фостер. Дурьдсан зохиол. 426-р тал. «Резолюции УП все-мирного конгресса Коммунистического Интернационала» М., 1935. с. 22.

4. «Арван их харилцаа»-г суралцах лавлалт. Хөх хот. 1977. 90 дэх тал

дайныг эсэргүүцсэн үзэл санаа, ардын өргөн нэгдсэн фронтын тактикийг Коминтерний VII их хурлаас сайшаасан шинэ стратеги, тактикийн үндсийг тусгажээ. «Японыг эсэргүүцэж, эх орноо аврахыг ард түмэнд уриалах нь» хэмээх 1935 оны 8-р сарын 1-ний тэрхүү тунхаглал нь Коминтерний гүйцэтгэх хороогоор хэлэлцэн сайшаагдаж улмаар Европт (Парист) олон хувь хэвлэгдэж Хятад руу тараагдаж байжээ. Хятадын коммунист намаас бүх нам, улс төрийн бүлэглэлүүдэд анх удаа хандаж буй уг уриалгад «улс орны бүх хүчин чадлыг Японыг эсэргүүцэж эх орноо аврах ариун үйлсэд зориулахын тул иргэний дайныг зогсооё» гэж уриалжээ.⁵

Гэтэл 1935 оны 11-р сарын 13-нд гаргасан ХКН-ын Төв Хорооны болон мөн сарын 28-нд гаргасан Хятадын ажилчин, тариачны ардчилсан төв засгийн газар, хувьсгалт цэргийн зөвлөлийн тунхаглалуудад Хятадыг колоничлолын газар болгох гэсэн Чан Кайшийнхны аюулыг зааж гагцхүү Японыг эсэргүүцэж, Чан Кайшитэй тэмцэх нь Хятадын ард түмний цорын ганц зам гэж дурджээ.⁶ 1935 оны 8-р сарын 1-ний тунхаглал, 11-р сарын 25-ны уриалгыг ХКН-ын удирдлага сар шахам авч хэлэлцээд Төв Хорооны Улс төрийн Товчоогоор баталсан «Намын одоогийн байдал ба зорилтын тухай шийдвэр» (Ваяабао, 1935 .12. 25)-т бас л «манай намын тактикийн чиг шугам бол орчин үеийн шатан дахь гол дайсан болсон Японы империализм, улс орноосоо урван тэрсэлсэн гол дайсан Чан Кайшийн эсрэг Хятадын ард түмний бүх хувьсгалт хүчийг дайчлан нягтруулж, зохион байгуулахад оршино. Иргэний дайныг үндэсний хувьсгалт дайнтай холбох хэрэгтэй»⁷ гэжээ.

Энэ шийдвэрийн үндсээр мөн сарын 27-нд Мао Зэдун Шэньси мушийн намын идэвхтний хуралд тавьсан илтгэлдээ «...гадаадын эзэрхэг түрэмгийтэн ба дотоодын хувьсгалыг эсэргүүцэх хүчинтэй байлдах хэрэгтэй болно.»⁸ гэснээс биш, шийдвэр, итгэлийн аль алинд нь Чан Кайшийн бүлэгтэй хэлэлцэн тохирохын чухлыг хүлээн зөшөөрөөгүй юм. Хэдий тийм боловч үндэсний нэгдсэн фронтын шийдвэрийг тунхаглаж, тактикийг боловсруулснаараа ХКН-ын ТХ-ны Улс төрийн Товчооны Ваяабао (умард Шэньси)-д болсон хурлыг чухал ач холбогдолтой хурал гэж үздэг ажээ.

Мао Зедуны өөрийнх нь тодорхойлсноор дотоодын харгис эрхтэн, компрадор (зууч) хөрөнгөтөн ангиас хувьсгалыг эсэргүүцэх хүч нь ард түмний хувьсгалт хүчнээс ихээхэн давуу болжээ. Тэгэх тусмаа Чан Кайшийн бүлгийг улам цааш түлхэх биш, харин Японыг эсэргүүцэх нэгдсэн фронтын үндсэн дээр өөртөө ойртуулах шаардлагатай байв. Энэ үед Гоминданы дотор ч Японыг эсэргүүцэх жигүүр хүчтэй болж 1935 оны 11-р сард хуралдсан V их хурлынхаа дараагаар Японы талыг баримталсан Нанжины засгийн газрын дарга Ван Цзинвэйг огцруулж, оронд нь Чан Кайшин гарч иржээ. 1935-оны 12-р сарын 9-нд Бээжингийн оюутны сүрт жагсаалаар эхэлсэн эх оронч хөдөлгөөн иргэний дайныг зогсоож, Японыг эсэргүүцэхийг шаардсан нь Ханьжоу, Тяньцзин, Шанхай зэрэг том хотуудын оюутан, ажилчдыг хамарч байв. Чан Кайшин тухайн үеийн гадаад дотоод байдалд дүгнэлт хийгээд засгийн газрынхаа гадаад бодлогыг тодорхойлохдоо, Японыг

5. К. В. Кукушкин . Коминтерн и единый национальный Антияпонский фронт в Китае. (1935— 1943) —«Коминтерн и Восток» М. , 1969. с . 350 . Материалы по истории китайской революции» , т . Ш , Пекин . 1957. с. 142

6. Ху Хуа. «Чжунго гэминши Цзяни» (Хятадын хувьсгалын түүхийн лекц) Бээжин , 1980 , 1-р боть. 397-р тал.

7. Отто Браун. Хятадад хийсэн тэмдэглэл. 1932—1939. УБ ., 1980. тал 216- 217.

8. Мао Зедуны сонгомол зохиол. 1-р боть. 1955 он. Бээжин. 35-р тал.

эсэргүүцэх болон түүнтэй хийх дайн гарцаагүй асуудал гэдгийг мэдэгдэж байв. Гэхдээ Хятадад Японы империализмын нэвтрэх нь Хятадыг сонирхогч өөр гүрнүүдтэй мөргөлдүүлнэ гэж тэр найдахын хат Японы империализмын гол зорилго нь Хятадтай бус, ЗХУ-тай байлгах явдал гэж таамаглаж байсан нь⁹ оргүй ч зүйл биш байв.

Европт фашист Итали, гетлерийн Германы дайнч түрэмгий бодлого улам гаарч, Алс Дорнодод Японы «ноёрхол» хэрэгжих төлөвтэй болмогц АНУ, Англи тэргүүтэй өрсөлдөгч империалист гүрнүүд эрх ашгаа хамгаалахын тул Японыг Гоминданы засгийн газраар эсэргүүцүүлэх зорилгоор түүнд туслаж эхлэв. Гоминданы эрх баригчид Америкийн тусламжийг Японыг эсэргүүцэхээр Хятадын коммунистуудыг эсэргүүцэхэд илүү ашиглаж байв. Ийм хүнд нөхцөлд Хятад орныг аврах найдвар нь Хятадын коммунист нам, түүний хяналтаа тогтоосон зөвлөлтийн районууд болж байв. Энэ талаар Георгий Димитров Коминтерний VII их хуралд тавьсан илтгэлдээ «Ард түмний хөдөлгөөн өрнөж, тус орны газар нутгийн нэлээд хэсэгт зөвлөлтийн район үүсч, улаан арми байгуулагдсан Хятадад бол Японы империализм дээрмийн халдлага үйлдэж Нанжины засгийн газар урвасан нь Хятадын ард түмний оршил тогтнолд аюул учруулав. Иймд Хятадын зөвлөлтийн районууд нь Хятадыг империалистууд боолчлон хуваахын эсрэг тэмцлийг нэгтгэгч төв, Хятадын ард түмний нийт үндэсний тэмцлийг явуулах зорилгоор империализмыг эсэргүүцэгч бүх хүчийг нэгтгэгч төв болж байна»¹⁰ гэж өндөр үнэлсэн нь нэг талаар ХКН-ын хойшлуулшгүй зорилтыг тодорхойлж байв. Ийм хариуцлагатай үүргийг биелүүлэхэд ХКН-д тохиолдох бэрхшээл багагүй байсан нь мэдээж юм. Ажилчин, тариачин, хотын жижиг хөрөнгөтний давхаргын санал шаардлагын дагуу ХКН-аас Чан Кайши-д хандаж Японы булаан эзлэгчийг эсэргүүцэх үндэсний өргөн фронт байгуулах талаар тавьсан саналыг тэр няцаасаар байв.

1934-1935 онд Квантуны арми Бээжинг оруулан автономит улс байгуулах оролдлого хийхэд үндэсний засгийн газар хэрэг дээрээ найр тавиад түүнийгээ «эн тэргүүнд дотоодын эсэргүү хүчийг дарж, дараа нь гадаадын дайсныг цохих бодлого»¹¹ гэгчээр хаацайлж байв. Үүнийхээ дагуу Нанжины засгийн газар Манжуурын Жан Золины хүү «Залуу генерал» Жан Сюэляны армийг баруун хойд Хятадын коммунистуудтай тэмцэхийг шаардсан боловч цэргүүд нь Японыг эсэргүүцэж эх орноо аврахыг эрхэмд үзэж коммунистуудтай байлдахын оронд тэдэнтэй ах дүү болох эрмэлзлэл нь давамгайлж байв.

Тийнхүү Хойд Шэньси-д бослого гаргаж Хятадын улаан армитай хамтран ажиллахыг хүссэн генерал Чжан Сюэлян, Ян Хучэн нар тэднийг илбэн тохинуулахаар ирсэн Чан Кайшийг 1936 оны 12-р сарын 12-нд олзлон баривчилж коммунистуудтай байлгах тушаалаа өөрчилж Японыг нэгдсэн фронтоор эсэргүүцэхийг шаарджээ. Чан Кайшиг Сианьд хоригдсон даруй ХКН төлөөлөгчөөрөө Жоу Энълайг 12-р сарын 16-нд, дараа нь Цинь Бансянь, Е Цзяньин нарыг томилон явуулж хэлэлцээ хийлгэв.¹² Хятадын улаан армийн ерөнхий командлагч Жү Дэ¹³ Чан Кайши үндэсний фронт байгуулах урьдчилсан зөвшөөрөл амлаж байж суллагдсан «Сианийн хэрэг явдал » гэгч энэ бөгөөд түүгээр Японыг эсэргүүцэх нэгдсэн фронт нээх нь хойшлуулшгүй зорилт болсон нь харагджээ. Гэвч «Сианийн хэрэг явдал»-ын

9. З. Д. Каткова. Внешняя политика гоминьдановского правительства в период антияпонской войны. (1937—1945), М., 1978. с. 15.

10. Георгий Димитров. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг. УБ., 1982, 167, 168-р тал.

11. Paul H. Clyde. The Far East. New Delhi 1963. p. 587.

12. Jian Bozan, Sha Xunzeng and Hu Hua. A Concise History of China. Beijing, 1981. p. 196, Ху Хуа дурьдсан зохиол. 416-р тал.

13. Уильям З. Фостер. Дурьдсан зохиол. 426-р тал.

дараагаар ч гэсэн хоёр намын хэлэлцээ тодорхой үр дүнгүй нэлээд гуацаа өнгөрчээ. Учир нь Мао Зэдун Сианийхантай хамтарч Чан Кайши болон Нанжины засгийн газрын эсрэг тэмцэхийг урьдал болгосноос биш харин тэдэнтэй хамтран ажиллахыг хичээсэнгүй. Түүний энэ алдааг ч Коминтерн цаг алдалгүй анхааруулж байжээ.¹⁴

Хятад дахь үндэсний фронтын талаархи нам хоорондын ийм зөрчлийг зөвхөн 1937 оны 2-р хагасаас буюу Төв Хятад руу Япон дайрнаас хойш хоёр сарын дараа шийдвэрлэжээ. Түүхэнд Люгоуцзяо буюу Марко Полын гүүрийн «золгүй явдал» гэгдэх зэвсэгт мөргөлдөөнөөр Хятад-Японы 8 жил үргэлжилсэн зарлаагүй дайн эхэлсэн билээ. Үүний эх үүсвэр нь Бээжингээс баруун өмнө холгүй орших Ванпин хотыг Японы цэрэг 1937 оны 7-р сарын 7-ны шөнө дайрахад хотын гарнизон эсэргүүцэл үзүүлжээ. Гэвч Японы тал дайралтаа зогсоох шинжгүй, харин Бээжин, Тяньцзинь районд нисэх онгоц 100 гаруй, цэрэг 20000-ыг аль хэдийнээ байрлуулаад¹⁵ Япон, Манжуур, Солонгосоос их хэмжээний нэмэгдэл хүч ирүүлэхээр дуудсан байжээ.

Харин түрэмгийллээс улс орноо аврах хариуцлагатай цаг тулгарсан ийм нөхцөлд орон даяар өрнөсөн шахалт шаардлагын эрхээр 1937 оны 9-р сарын 23-нд Чан Кайши үндэсний нэгдсэн фронт байгуулах хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Үүний тул коммунист нам багагүй буулт (зөвлөлүүдийг өөрчлөн байгуулах, улаан армийн нэрийг нь өөрчлөж Гоминдааны цэргий зөвлөлд тусгай болзолтойгоор захируулах, газрын том эздийн хөрөнгө хураахыг түр зогсоох зэрэг) хийсэн боловч ХКН-ын улс төрийн эрх хэмжээг Гоминданаар хүлээн зөвшөөрүүлжээ. ХКН, түүний цэрэг армийн оршин тогтноход аюул учирч байсан энэ үед байдал ийнхүү өөрөө эргэж ХКН-д илүү ашигтай болсон нь гадаад, дотоод хүчин зүйлээс шалтгаалсан билээ. Энэ нь юуны өмнө Коминтерний үйл ажиллагаатай шууд холбогдоно. АНУ-ын вангийн их сургуулийн түүхийн профессор Паул Хибберт Клидийн бичсэнээр коммунистуудын цэрэг эсрэг талын хүрээллээс гарч, зүүн тийш дөхөх зорилгоор аялсан 6000 милийн урт аяны эцэст анх Цзянси-гаас гарсан 90000 хүнээс Шэньси-д ирсэн нь 20000 болж, коммунистуудын алдагдлын хирээр Гоминданыхан хожиж байсан хүнд үед Коминтерний нэгдсэн фронтын стратеги, тактикт гарсан өөрчлөлт нь Хятадын коммунистуудыг аварсан юм. 1935 оны энэ өөрчлөлтөөр нацист Германы эсрэг тэмцлийг Лига Нацийн шугамаар Орос өрнүүлж, ядарч сулдсан Хятадын коммунистууд үндэсний засгийн газраа эсэргүүцсэн иргэний дайнаас Японы түрэмгийлэгчдийн эсрэг Хятадын нэгдсэн фронтыг хамгаалах бодлогод шилжих боломж олгожээ.¹⁶ 1937 онд Хятадад Японы довтолсны дараахан Хятадын засгийн газар ЗХУ-д мэдэгдэж, улмаар харилцан үл довтолох тухай Зөвлөлт—Хятадын гэрээг 1937 оны 8-р сарын 21 нд Нанжинд байгуулсан нь Коминтерний VII их хурлын дараагаар Хятадын хувьсгалт дайнд үзүүлсэн олон улсын чанартай бас нэг чухал дэмжлэг боллоо. Энэ үед Лига Наци-д ЗХУ Хятадыг өмгөөлөн, Японы түрэмгийллийг таслан зогсоох олон улсын эрхийн арга хэмжээ авахыг шаардаж байв. Хятадын өөрийн нь түүхчид Жянь Бозянь, Шао Хунзен, Ху Хуа нарын иш татсан номд тухайн үеийн байдлыг

14. А. С. Титов. Из истории борьбы за единый фронт в Китае. (1935-1937) «Китай в Новое и новейшее время.» М., 1981. с . 166.

15. Советско-Китайские отношения. 1917—1937, т. 1 , 1959. док . № 10 с. 160.

16. Paul H. Clyde The Far East New Delhi. 1963, p. 728.

бодитойгоор тодорхойлж «Японыг эсэргүүцэх дайн эхэлснээс хойш Хятадад жинхэнэ тусалж байсан гадаадын цорын ганц орон бол Сталинаар удирдуулсан Зөвлөлт Холбоот Улс байна. Хятадтай ЗХУ-ын байгуулсан харилцан үл довтолцох тухай 1937 оны 8-р сарын 21-ний гэрээ нь нөхөр ёсны хүчтэй дэмжлэгийн баталгаа болов. Санхүү, зээл, цэрэг зэвсгийн хэлбэрээр Хятадад үзүүлж байсан Зөвлөлтийн тусламж нь 1941 оны сүүлчээр Хятадад Англи, АНУ болон бусад орны үзүүлсэн тусламжаас 5 дахин давж байна. Дайны хамгийн хатуу хүнд үед Зөвлөлт Холбоот Улс л тусалж байв. Тэр үед Англи, АНУ нь «барсын тулалдааныг уулын оройд сууж ажиглах» бодлого баримталж..., 1938 онд дайнд хэрэглэж байсан Японы цэргийг бүх материалын 92%-ийг нийлүүлж..., Хятадын талд зөвхөн дайнаа үргэлжлүүлж байх төдий хэмжээний тусламж олгож байв»¹⁷ гэжээ.

Хятад дахь үндэсний фронтын үйл ажиллагаа бүхэлдээ үндэсний үзэл, ардын засаглал, ардын зол жаргал гэдэг Сун Ятсений «гурван зарчим»-д захирагдах болжээ. Зөвхөн энэ мэт харилцан зохицох бодлогын үр дүнд 1927—1937 оны иргэний дайн эцэс болж 1937—1945 онд Хятад нь Японыг эсэргүүцэх дайн явагдаж байв.

Энэ үед Зүүн Хойд Хятадад Японыг эсэргүүцсэн цэргийн янз бүрийн анги нэгтгэлүүд, ХКН-ын Төв Хорооны шийдвэрийн дагуу Японыг эсэргүүцэх Зүүн хойд нэгдсэн арми нэртэй боллоо. Ингэж эх суурь нь тавигдсан Хятадын хуурай замын 8-р арми нь 1937 оны намар 45 мянган хүнтэй¹⁸ хүчирхэг арми болтлоо өссөн бөгөөд түүний командлагчаар ХАЧА-ийн ирээдүйн алдарт жанжин Жү Дэ, Пэн Дэхуай нарын зэрэг эрэлхэг коммунистууд ажиллаж байв.

Гэвч нэгдсэн фронтоос Японыг эсэргүүцсэн дайны явцыг Чан Кайши зориуд саатуулсаар 1939 оноос эхлэн гол дайснаа коммунистууд гэж үзэж байсан нь түүнээс «коммунистуудын эсрэг хоёр дахь кампани» буюу 1941 оны 1-р сарын «золгүй явдал» –д хүргэж үндэсний нэгдсэн фронтыг хямралд оруулжээ.¹⁹

«1941 оноос хойш 1945 оны 9-р сард Японыг бууж өгөх хүртэл Хятадад хэрэг дээрээ хоёр дайн явуулж байв. Өмнө талд Гоминдан байршлын дайн явуулж ихэвчлэн идэвхгүй хамгаалалт хийж, умард ба зүүн умардад коммунистууд партизаны дайн явуулж байв. Энэ хоёр хүч нэг нэгнээ хардан сэжиглэж зэвсэглэсэн төвийг сахих бодлого баримталж байв. Тэдний хооронд зохицуулалт, төлөвлөгөө, хамтын ажиллагаа аль нь ч байсангүй»²⁰ гэж Австралийн их сургуулийн профессор, хятад судлаач К. П. Фитзжеральд бичжээ. Ийм байдлыг хятадууд 1936 оноос 1938 он хүртэл буй болсон стратегийн хориглолтын онол, Чан Кайшигийн буулт хийж «үл эсэргүүцэх» онол аль аль нь «хятад хүн хятад хүнээ хядах» иргэний дайныг сунжруулснаас Японы империализмыг яаралтай сөрж нэгдсэн хүчээр тэмцэхэд нь нэмэр болсонгүй. Гэхдээ империализмыг эсэргүүцэн фронт агуулгын хувьд бүрдэж хэлбэрийн төдий боловч байгуулагдсан явдал Хятадын ард түмний эх орноо чөлөөлөх урам зоригийг сэргээж, ХКН-ын нэр хүндийг өндөр өргөснөөр 1949 оны ардчилсан хувьсгалын ялалтанд тус дөхөм үзүүлсэн нь илт билээ. Эдгээр нь Коминтерний VII

17. A Concise History of China. p. 204.

18. Мөн тэнд. 199 дэх тал.

19. Новейшая история Китая (1928—1949) М., 1984. с . 200—201.

20. С. Р. Fitzgerald. The Birth of Communist China. Suffolk. 1964. p. 89.

21. «Хүнцн» («Улаан туг») 1982, № 8, 43-р тал. (монгол хэл дээр)

их хурлаас дэвшүүлсэн ардын фронтын ленинч бодлогын зөв болохыг нотлон харуулсан юм. Коминтерний VII их хурлын шийдвэрийг буруутгах, түүний ролийг үгүйсгэх оролдлого, Хятад дахь үндэсний нэгдсэн фронтын үүсэл, хөгжил, стратеги, тактикийг нэг хүний, тухайлбал, Мао Зэдуны гавьяа болох, Коминтерн дэх ХКН-ын төлөөлөгч (Ван Мин)-ийг буюу Коминтернийг бүхэлд нь зэмлэх оролдлого²² ХКН-ын дотор гарсаар ирлээ.

Хятадын хувьсгалын түүхэнд үндэсний нэгдсэн фронтын биелүүлэх үүрэг Хятадыг чөлөөлснөөр дууссан гэж Хятадын удирдлага үзэхгүй байна. Харин түүнийг өөр зорилгод ашиглаж байна. Энэ талаар ХКН-ын төв хэвлэлд бичихдээ, «Шинэ үеийн нэгдсэн фронтын үндэс зорилт бол социалист шинэчлэлтийн хүчирхэг улсыг байгуулах, эх орноо нэгтгэх их үйлсийг бэхжүүлэх, жанжлалын эсрэг олон улсын тэмцлийг өрнүүлэх энэ гурван их зорилтод үйлчлэх явдал мөн»²³ гэжээ. Гэвч эдгээр зорилтын нэг буюу жанжлалын эсрэг олон улсын тэмцлийг өрнүүлэх гэдэг зорилт нь империализмыг эсэргүүцэх үндэсний нэгдсэн фронтын нийтлэг зорилтыг бүрхэгдүүлж битүүдээ ЗХУ-ын эсрэг олон улсын нэгдсэн өргөн фронт байгуулахад чиглэгдэж буй нь илэрхий байна. БНХАУ-ын нэгдсэн фронтын өнөөгийн бодлого империализмыг эсэргүүцсэн нэгдмэл фронтын ленинч стратеги, тактикийг ийнхүү сөрөн зогсож байгаа нь ХКН-ын нэгдсэн фронтын бодлого зөрчилтэй байгааг харуулж байна. Ялангуяа «дайнар дайныг эсэргүүцэх» «дайн, энх тайван хоёр ээлжлэх» гэх мэтийн маоист баримтлал бол мөн л Коминтерний тунхагласан империализм, дайны эсрэг олон улсын нэгдсэн фронтын үзэл санаанд нийцэхгүй байгаа зүйл мөн.

Хятадын түүх бичлэгт их бага дайны түүх, түүний дотор дэлхийн II дайны түүхийг гуйвуулах оролдлого нь өрнөдийн суртал нэвтрүүлгээс дутуугүй явагдаж байна. Тэд 1937 оны Хятад—Японы дайнар дэлхийн II дайн эхэлж Хятадын коммунистууд Японы империализмтэй ганцаар тулж явсан²⁴ мэтээр үзэж ЗХУ-ын зүйл бүрийн сэтгэл харамгүй тусламж, ялангуяа олон улсын ганцаардмал байдалд Хятадыг оруулахгүйн тул түүнтэй дипломат харилцаагаа сэргээж, улмаар харилцан үл довтлох гэрээ (1937) байгуулсан эрх, зүйн тусламжийг мартаж өсгүй. ХКН-ыг үүсгэн байгуулахаас аваад Японыг эсэргүүцэх дайны үед үндэсний нэгдсэн фронт байгуулах стратеги, тактикийг боловсруулахад үзүүлсэн Коминтерний үр нөлөөг тэд үгүйсгэх буюу бууруулж, буруутгаж чадахгүй. Яагаад гэвэл, ХКН-ын үүсэл, бэхжил, Японы империализмыг ялахад оруулсан Хятадын ард түмний хувь нэмэр, ардчилсан ба социалист хувьсгалын ялалт цөм л ЗХУ, Коминтерн, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний өрнөл өсөлт, дайн, фашизмыг эсэргүүцсэн дэлхийн хөдөлмөрчдийн шударга тэмцлийн үр хөврөлтэй салшгүй холбоотой. Үүнийг Хятадын ард түмэн сайн мэдэх учраас Мао Зэдун өөрөө ч дээрх тус дэмжлэгийн ач холбогдлыг тухайн үедээ өндөр үнэлж Хятадын хувьсгалын ялалттай шууд холбож байсан удаатай. Хятадын ард түмнээс империалист Японы эсрэг явуулсан дайны бүхий л жилийн турш Японы армийн ихээхэн хүчийг ЗХУ зүүн хил дээрээ торгоон барьж Хятад руу илгээхийг нь саатууж байлаа. Япо-

22. А. М. Григорьев. Освещение истории революционного движения в Китае (1919—1949) в литературе КНР (1977—1980)—«Историческая наука в КНР. М., 1981, с. 221—247, Сян Цин. К вопросу о Коминтерне и Китайской ревюлюции—«Синьхуа Юебао» 1980, № 4.

23. «Хунци» 1983, № 24, 23-р тал.

24. «Гуанмин жибао», 1978. ҮП . 7

-ны армийн нисэх хүчний тэн хагасаас илүү нь, танкийн гуравны нэг нь сая гаруй хүнтэйгээ маневарлаж байсан Квантуны армийг буулгаж авсан. ЗХУ-ын чөлөөт улаан армийн хувь нэмэр, түүний түүхэн ач холбогдолыг үгүйсгэх ямар ч үндэсгүй. Японы империализмыг 1954 онд ялахад ЗХУ-ын гүйцэтгэсэн шийдвэрлэх ролийг Японы армийн дээд командлалаас эхлээд холбоотон (АНУ, Англи)-ны цэргийн дээд тушаалтнууд хүртэл хүлээн зөвшөөрсөн нь түүхнээ нэгэнт тэмдэглэгджээ.

Алс Дорнодод Японы милитаризмыг бутцохисон явдал дэлхийн II дайныг эцэс болгож, Ази, Дорно дахинд империализмын колоничлолын систем задран унах үйл явцыг түргэсгэв. 1945 оны 8-р сард Вьетнамд хувьсгал ялж, 1945 оны 9-р сарын 2-нд Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улсыг тунхаглав. Зөвлөлт, Монголын ах дүү армиуд Зүүн—Хойд Хятад, Өвөр Монголыг Японы дарлалаас ангижруулж, зөвлөлтийн цэрэг умард Солонгосыг чөлөөлөв. Дараа нь Индонези, Бирм, Энэтхэг, тусгаар тогтнолоо зарлав. Үүгээр Ази, Номхон далайн районд колоничлолын систем задран унаж эхлэв. Ялангуяа 1949 онд Хятадын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл, Хятадын хувьсгал ялж БНХАУ байгуулагдав.

1930-аад оны эхэн үед Дорно дахины орнуудын коммунист, ажилчны намууд нь ихэвчлэн шинэ залуу бөгөөд зарим нь нууц байдалд ажиллах шаардлагатай байсан боловч цөм империалист түрэмгийлэлийн эсрэг, үндэсний эрх чөлөөний төлөө ард түмнийхээ тэмцлийг манлайлж байлаа.

Тэдгээр намууд ЗСБНХУ болон Коминтернтэй нягт холбоо тогтоож, юуны өмнө империализмын эсрэг нэгдсэн фронтоор тэмцэх тухай Коминтерний VII их хурлын заалтыг үйл ажиллагаандаа удирдлага болгосон юм. Японы милитаристуудын «Агуу их Ази»-д жанжлах төлөвлөгөөг ойлгож мэдсэн Индонезийн зүүний намууд 1930-аад оны сүүлчээс эхлэн Индонезийн тусгаар тогтнолыг дав даруй байлдан олох лозунг түр хойшлуулж, Евролт фашизмын аюулд өртөх болсон Нидерландын ардчилсан хүчтэй хамтран, фашизмын эсрэг холбоо тогтоох шийдвэр гаргажээ.²⁵ фашизмын эсрэг нэгдсэн фронт Энэтхэг—Хятадын хойгийн орнуудад мөн л ийм замаар байгуулагдаж байв. Энэтхэг—Хятадын коммунист намын төв хороо 1936 оны 7-р сарынхаа бүгд хурлаар хувьсгалын тактикийн тухай хэлэлцээд «Францын империализмын ноёрхлыг устгаж, үндэсний тусгаар тогтнолыг зарлах» лозунг түр орхиж, империализмыг эсэргүүцэх Энэтхэг—Хятадын ард түмний өргөн фронт байгуулах шийдвэр гаргажээ.²⁶ Бүгд хурлын энэ шийдвэр нь Вьетнамын хувьсгалын өрнөлтийн шинэ шатыг нээсэн юм.

Энэтхэгийн коммунист нам 1935-1939 онд зүүнтний элементтэй хийх тэмцлийн дунд нэгдсэн фронтын бодлогыг хэрэгжүүлж байв.

Коминтерний VII их хурлын шийдвэрийг МАХН-ын Төв Хороо 1935 оны 9-р сарын 28-нд Тэргүүлэгчдийн хурлаар авч хэлэлцжээ. Уг хурал Коминтерний шийдвэр нь империализм, Феодализмыг эсэргүүцсэн МАХН-ын гадаад, дотоод улс төрийн бодлоготой бүрэн нийцэж байгааг нотолсон байна.²⁷ Коминтернтэй нягт хамтран ажиллаж,

25. А. Б. Беленький. Из истории Либерально-буржуазного национализм в Индонезии.—«Юго-восточная Азия. История, Современность». М., 1983. с . 51.

26. Хо Ши Мин. Сочинения (1920—1969). Ханой. 1971. с . 40, 385.

27. С. Дамдинсүрэн. «МАХН-ын олон улсын эв санааны нэгдлийн төлөө дайн, фашизмын аюулын эсрэг Коминтерний шугамыг хэрэгжүүлэх тэмцэл».—«МАХН-ын түүхийн судлал» эрдэм шинжилгээний өгүүллийн эмхтгэл. № 9, УБ ., 1974, 35-р тал.

түүний зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгосон МАХН империализмыг эсэргүүцэх ардын фронтыг бүх талаар дэмжих, тэмцэж байгаа Испанийн ард түмэнтэй эв санааны нэгдэлтэй байж, түүнд эд материалын тусламж үзүүлэх, Японы эсрэг явуулж байгаа хөрш зэргэлдээ Хятадын ард түмний тэмцлийг дэмжин туслах бодлого баримталж байв. БНМАУ-ын засгийн газар Алс Дорнодод Японы түрэмгийллийн аюулыг сэргэмжлэн зайлуулахад чиглэсэн Монгол—Зөвлөлтийн 1936 оны протокол гэрээ байгууллаа. Эдгээр арга хэмжээ нь Монголын ард түмэн, түүний дайчин манлай МАХН нь интернационалч үүргээ нэр төртэй биелүүлж, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохоо харуулсан юм.

Коминтерний VII их хурлын шийдвэр нь олон улсын коммунист хөдөлгөөн дэх «зүүний» сектант бодлогын алдааг эцэс болгон дорно дахины колони ба хараат орнуудад империализмын эсрэг нэгдсэн фронт байгуулах стратеги, тактикийг баталснаараа тэдгээр орны ард түмний хувь заяанд чухал үүрэг биелүүлсэн төдийгүй намуудын марксист—ленинист өсөлт бойжилтод хүчтэй нөлөө үзүүлжээ.

Дорно дахины коммунист, ажилчны олонхи намууд марксизм-ленинизмын тугийг өндөрт өргөн олон улсын коммунист хөдөлгөөний онол, практикийг уламжлан хөгжүүлж, өөр өөрийн оронд шинэ нийгэм байгуулах тэмцэл, Ази болон дэлхий дахины энх тайван, социализмын ариун үйл хэргийн төлөө тэмцэлд үлэмжийн амжилт олсоор байна.

ЗНАЧЕНИЕ РЕШЕНИЙ УП КОНГРЕССА КОМИНТЕРНА В РАЗВИТИИ НАЦИОНАЛЬНО-ОСВОБОДИТЕЛЬНОЙ БОРЬБЫ НАРОДОВ ВОСТОКА И СОВРЕМЕННОСТЬ

(Резюме)

В условиях, когда фашистскими режимами в Германии и Италии велись захватнические войны в Европе и Африке, когда империалистическая Япония приступила к реализации своих экспансионистских планов в Азии, VII Конгресс Коминтерна (июль-август 1935 г.), поддерживая мирную инициативу Советского Союза, в своих резолюциях подчеркнул о необходимости создания в международном масштабе единого народного фронта борьбы против фашизма и ядром которого должен стать всемирный единый рабочий фронт.

VII Конгресс Коминтерна в своих решениях определил лизм и фашизм как источник агрессивных захватнических войн, что имеет свое актуальное значение в наши дни, когда по вине Милитаристского курса агрессивных кругов империалистической реакции, прежде всего администрации США крайне обострилось современное политическое положение в мире. Характеризуя нынешнюю международную обстановку и исходя из миролюбивой внешней политики Советского Союза, на последнем пленуме ЦК КПСС тов. М. С. Горбачев подчеркнул, что «Никогда прежде над человечеством не нависла столь страшная угроза, как в наши дни. Единственный разумный выход из создавшегося положения—это договоренность противостоящих сил о немедленном прекращении гонки вооружений—прежде всего ядерных—на Земле и недопущении ее в Космос».

Важное значение для судеб народов Востока, в том числе китайского народа, китайской революции имели решения УП Конгресса Коминтерна.

В докладе Генерального секретаря Коминтерна г. Димитрова, в решениях УП Конгресса выдвигалась задача последовательного осуществления компартиями стран Востока политики создания единого народного фронта борьбы против империалистических, колониальных войн. Китайская делегация в Коминтерне, которую возглавил член Политбюро ЦК КПК Ван Мин, активно участвовала в выработке Коминтерном стратегии единого антифашистского фронта. Основы ленинского положения о необходимости создания единого антиимпериалистического фронта были изложены в «Обращении КПК к народу об отпоре Японии и спасении родины» от 1 августа 1935 г. В этом докладе компартия призывала всех партийных и политических групп пировок Китая прекратить гражданскую войну внутри страны, мобилизовать все силы на борьбу за сопротивление японской агрессии и спасение родины. В обращении содержался прямой призыв к соглашению между гоминьданом и компартией. Эти призывы полностью соответствовали задачам, стоявшим перед китайским народом, о которых автор приводит в качестве доказательства такие события как «движение 2 декабря 1935 г.» в Пекине и «Сианьское событие» 12 декабря 1936 г.

Единый национальный, антияпонский фронт был создан в сентябре 1937 г. после того, как Япония 7 июля 1937 г. развернула широко масштабную войну против Центрального Китая. Созданный по инициативе КПК и при активной поддержке Коминтерна единый национальный фронт сыграл исключительно важную роль в подготовке китайского народа к борьбе против японской агрессии. Однако внутри партии отсутствовало единство по выработке стратегии и тактики единого фронта. Левосектантская позиция Мао Цзэдуна всячески затягивала формирование единого фронта, настаивая на необходимости одно-временного ведения вооруженной борьбы как против внешней (японской) агрессии, так и против внутренней (чанкайшистской) реакции. Для преодоления этой преграды требовалось не мало усилий со стороны ЦК КПК и Коминтерна.

Решения УП Конгресса Коминтерна имели огромное значение для вьетнамских коммунистов. Индокитайские коммунисты благодаря решениям этого конгресса правильно определили направления и формы своей организационной работы на всем протяжении Вьетнамской революции. Такую же роль сыграло решение ХП Конгресса Коминтерна для других партий стран Востока, в том числе для МНРП.

УП Конгресс Коминтерна не только выработал стратегию и тактику единого антиимпериалистического фронта в колониальных и зависимых странах Востока, но и оказало сильное влияние на марксистско-ленинскую закалку коммунистических партий этих стран.